



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2025 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99023682
Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Утас: 99862066
Цахим хаяг: peakomauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.05 № 128

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 8 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 55.7 хувиар өссөн байна.

4525020212

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 98.3 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,179,177.53	133,523,871.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	36,725,773.43	104,596,814.68
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	36,725,773.43	104,596,814.68
31210	Төгрөг	36,725,773.43	104,596,814.68
31211	Төрийн сангийн харилцах	36,725,773.43	104,596,814.68
35	БАРАА МАТЕРИАЛ	16,453,404.10	28,927,057.20
35100	Түүхий эд материал	1,839,497.80	1,906,277.20
35130	Эм боох материал	1,839,497.80	1,906,277.20
35400	Хангамжийн материал	14,613,906.30	27,020,780.00
35410	Бичиг хэргийн материал	185,000.00	255,000.00
35420	Аж ахуйн материал	1,997,029.00	2,989,847.00
35460	Хүнсний материал	9,610,417.30	15,016,233.00
35470	Бусад хангамжийн материал	2,821,460.00	8,759,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,229,747,183.86	1,211,135,824.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,229,747,183.86	1,211,135,824.39
39200	Биет хөрөнгө	1,017,897,183.86	999,535,824.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(153,584,202.60)	(184,301,043.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	22,515,100.00	48,227,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,193,496.97)	(20,758,433.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,614,134.57	59,614,134.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,492,509.90)	(43,436,053.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,470,518.32	23,470,518.32
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,645,109.56)	(13,493,948.50)
39217	Ном	2,193,780.00	2,193,780.00
39300	Биет бус хөрөнгө	211,850,000.00	211,600,000.04
39301	Програм хангамж	2,124,300.00	2,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,374,299.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,850,000.00	210,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,282,926,361.39	1,344,659,696.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,282,926,361.39	1,344,659,696.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,282,926,361.39	1,344,659,696.27
51100	Засгийн газрын оруулсан капитал	558,407,638.00	558,407,638.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	558,407,638.00	558,407,638.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(429,851,582.41)	(368,118,247.53)
51210	Өмнөх үеийн үр дүн	(428,265,029.31)	(429,851,582.41)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,586,553.10)	61,733,334.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,154,370,305.80	1,154,370,305.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,282,926,361.39	1,344,659,696.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,530,839.15	896,963,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,448,300.00	21,748,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,448,300.00	21,748,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,448,300.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,413,300.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	21,748,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,082,539.15	875,214,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,541,200.00	846,548,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,541,200.00	846,548,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,541,339.15	28,665,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,541,339.15	28,665,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	572,117,392.25	835,229,765.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,117,392.25	835,229,765.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	572,117,392.25	826,913,897.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,469,798.23	586,195,152.99
210101	Үндсэн цалин	258,372,076.03	394,139,055.76
210102	Нэмэгдэл	108,643,829.20	172,336,517.23
210104	Урамшуулал	9,453,893.00	19,719,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,962,931.12	72,159,940.76
210201	Тэтгэврийн даатгал	32,376,536.54	49,794,033.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,792,827.80	5,859,055.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,981,462.28	3,051,970.22
210204	Ажилгүйдлийн даатгал	707,632.21	2,690,976.29
210205	Эрүүл мэндийн даатгал	7,104,472.29	10,763,904.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,252,339.15	26,103,532.58
210301	Гэрэл, цахилгаан	7,165,666.27	7,799,888.78
210302	Түлш, халаалт	9,984,766.88	10,492,093.92
210303	Цэвэр, бохир ус	6,101,906.00	7,811,549.88
2104	Хангамж, бараа материалын зардал	4,688,122.70	4,129,702.00
210401	Бичиг хэрэг	320,500.00	321,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	365,919.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,130,111.00	2,491,783.00
210408	Бараа материал акталсны зардал	2,871,592.70	1,096,919.00
2105	Нормативт зардал	62,238,531.40	75,251,989.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	215,037.20	148,320.60
210502	Хоол, хүнс	62,023,494.20	75,103,669.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,542,500.00	4,714,600.00
210604	Урсгал засвар	1,542,500.00	4,714,600.00
2107	Томилолт, зочны зардал	799,000.00	1,801,000.00
210702	Дотоод албан томилолт	799,000.00	1,801,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,668,561.22	3,098,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,020,561.22	2,450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,495,608.43	53,459,979.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,887,130.00	4,659,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,199,000.00	4,476,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,409,478.43	44,324,159.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,315,867.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,253,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8,253,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	62,267.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	62,267.42
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,586,553.10)	61,733,334.88
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,586,553.10)	61,733,334.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	563,117,539.15	875,214,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,082,539.15	875,214,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,541,200.00	846,548,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,541,200.00	846,548,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,541,339.15	28,665,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,541,339.15	28,665,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	522,888,883.72	803,379,258.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,888,883.72	803,379,258.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,888,883.72	795,063,391.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,469,798.23	586,195,152.99
210101	Үндсэн цалин	258,372,076.03	394,139,055.76
210102	Нэмэгдэл	108,643,829.20	167,974,517.23
210104	Урамшуулал	9,453,893.00	24,081,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,962,931.12	72,159,940.76
210201	Тэтгэврийн даатгал	32,376,536.54	49,794,033.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,792,827.80	5,859,055.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,981,462.28	3,051,970.22

210204	Ажилгүйдлийн даатгал	707,632.21	2,690,976.29
210205	Эрүүл мэндийн даатгал	7,104,472.29	10,763,904.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,252,339.15	26,103,532.58
210301	Гэрэл, цахилгаан	7,165,666.27	7,799,888.78
210302	Түлш, халаалт	9,984,766.88	10,492,093.92
210303	Цэвэр, бохир ус	6,101,906.00	7,811,549.88
2105	Нормативт зардал	62,620,265.00	80,509,485.00
210502	Хоол, хүнс	62,620,265.00	80,509,485.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,289,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,289,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,020,561.22	2,614,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,020,561.22	2,614,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,273,989.00	24,980,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,889,989.00	16,727,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,384,000.00	8,253,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,315,867.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,253,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8,253,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	62,267.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	62,267.42
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	40,228,655.43	71,835,341.25
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,681,983.00	3,964,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,681,983.00	3,964,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,681,983.00	3,964,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,681,983.00	3,964,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,681,983.00)	(3,964,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,546,672.43	67,871,041.25
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,179,101.00	36,725,773.43
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,725,773.43	104,596,814.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/тегрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(428,265,029.31)	1,284,512,914.49
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(428,265,029.31)	1,284,512,914.49
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн есөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(1,586,553.10)	(1,586,553.10)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(429,851,582.41)	1,282,926,361.39
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(429,851,582.41)	1,282,926,361.39
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(429,851,582.41)	1,282,926,361.39
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн есөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	61,733,334.88	61,733,334.88
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	558,407,638.00	1,154,370,305.80	(368,118,247.53)	1,344,659,696.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

дд	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	911,939,500.00	807,281,291.33	(104,658,208.67)	88.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	911,939,500.00	807,281,291.33	(104,658,208.67)	88.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	903,685,900.00	799,027,691.33	(104,658,208.67)	88.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,884,600.00	586,195,152.99	(90,689,447.01)	86.6
210101	Үндсэн цалин	482,094,200.00	394,139,055.76	(87,955,144.24)	81.8
210102	Нэмэгдэл	185,984,600.00	167,974,517.23	(18,010,082.77)	90.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	8,805,800.00	24,081,580.00	15,275,780.00	273.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,935,600.00	72,159,940.76	(6,775,659.24)	91.4
210201	Тэтгэврийн даатгал	53,677,800.00	49,794,033.93	(3,883,766.07)	92.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,313,400.00	5,859,055.38	(454,344.62)	92.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,157,300.00	3,051,970.22	(105,329.78)	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,157,300.00	2,690,976.29	(466,323.71)	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,629,800.00	10,763,904.94	(1,865,895.06)	85.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,165,800.00	26,103,532.58	(62,267.42)	99.8
210301	Гэрэл, цахилгаан	7,969,200.00	7,799,888.78	(169,311.22)	97.9
210302	Түлш, халаалт	11,150,000.00	10,492,093.92	(657,906.08)	94.1
210303	Цэвэр, бохир ус	7,046,600.00	7,811,549.88	764,949.88	110.9
2105	Нормативт зардал	82,549,800.00	80,509,485.00	(2,040,315.00)	97.5
210502	Хоол, хүнс	82,549,800.00	80,509,485.00	(2,040,315.00)	97.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,614,500.00	2,614,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,614,500.00	2,614,500.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,035,600.00	28,945,080.00	(5,090,520.00)	85.0

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,782,000.00	20,691,480.00	(5,090,520.00)	80.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,253,600.00	8,253,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,253,600.00	8,253,600.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,253,600.00	8,253,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,253,600.00	8,253,600.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	911,939,500.00	875,152,332.58	(36,787,167.42)	96.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	846,548,800.00	846,548,800.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	846,548,800.00	846,548,800.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,665,800.00	28,603,532.58	(62,267.42)	99.8
132001	Орон нутгийн төсвөөс	28,665,800.00	28,603,532.58	(62,267.42)	99.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	36,724,900.00	-	(36,724,900.00)	0.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	36,724,900.00	-	(36,724,900.00)	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		36,725,773.43	36,725,773.43	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		104,596,814.68	104,596,814.68	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	28.00	(1.00)	96.6
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	21.00	(1.00)	95.5
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	191.00	145.00	(46.00)	75.9
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	191.00	145.00	(46.00)	75.9
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	191.00	145.00	(46.00)	75.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	28.00	(1.00)	96.6
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	16.00	15.00	(1.00)	93.8
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэг нь "Боловсролын шинэ хуулийг өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж, цэцэрлэгийн бодлого, төлөвлөлт, сургалт үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг ахиулна" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус цэцэрлэг нь Дархан Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багийн 2-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох боловсролын үйлчилгээг бүрэн хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дугаар тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,733.3 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36,725.8	104,596.8	67,871.0
Авлага			-
Бараа материал	16,453.4	28,927.1	12,473.7
Үндсэн хөрөнгө	1,229,747.2	1,211,135.8	(18,611.4)
Нийт хөрөнгө	1,282,926.4	1,344,659.7	61,733.3
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,282,926.4	1,344,659.7	61,733.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,282,926.4	1,344,659.7	61,733.3

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 104,596.8 мянган төгрөг болж өмнөх оноос 67,871.0 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28,927.1 мянган төгрөг болж 12,473.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны нөхөн хангалтын зардлаар 6,862.2 мянган төгрөгийн ханын леги, стем тоглоом худалдан авч, ерөнхий гэрээний дагуу Монмийт трейд ХХК-нд өгсөн захиалгыг буруу төлөвлсөнөөс оны эцэст 5,649.0 мянган төгрөгийн хүнсний материалыг бүртгэсэн нь голлон нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,211,135.8 мянган төгрөг болж 18,611.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,964.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар Боловсролын ерөнхий газраас 13,408.5 мянган төгрөгийн 7 ширхэг зөөврийн компьютер хүлээн авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар "Угаалгын тоног төхөөрөмж" төслийн хүрээнд 8,340.0 мянган төгрөгийн автомат аяга таваг угаагч, ногоо хэрчигч нийт 21,748.5 мянган төгрөгийн хөрөнгийг Аймгийн засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01-А/450 захирамжийг үндэслэн эрхлэгчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний А/19 тоот тушаалаар үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэн, тайлант онд 44,324.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,344,659.7 мянган төгрөг болж 61,733.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 615,451.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 37,952.0 мянган төгрөг, нийт зарлагыг 653,403.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 88,560.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 704,012.3 мянга, орон нутгийн төсвийг 11,286.2 мянган төгрөгөөр бууруулж 26,665.8 мянга, нийт 730,668.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 142,536.5 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна. Тодруулбал Засгийн газрын 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнээр цалин хөлс нэмэгдсэн, гүйцэтгэлд үндэслэн хоолны зардлыг 11,193.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,179.4 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2,614.5 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшлын зардлыг 8,253.4 мянга, тогтмол зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 846,548.8 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 36,724.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,665.8 мянган төгрөг, нийт 911,939.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 846,548.8 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 36,725.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,665.8 мянган төгрөг, нийт 911,940.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарлагын гүйцэтгэл 807,281.3 мянган төгрөг буюу 88.5 хувьтай зарцуулж, 62.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, цалингийн зардлаас 90,689.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 6,775.6 мянга, хоол хүнсний зардлаас 2,040.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 5,090.5 мянга, нийт 104,596.8 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	71801	Сургуулийн өмнөх боловсрол	911,939.5	807,281.3	104,658.2	88.5
1	80111	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	28,665.8	28,603.5	62.3	99.8
2	80233	Хүүхэд хамгаалал	1,218.8	1,218.8	-	100.0
2	81605	Эрүүл мэндийг дэмжих	3,423.7	1,569.0	1,854.7	45.8
3	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	82,549.8	80,509.5	2,040.3	97.5
4	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	3,135.4	3,135.4	-	100.0
5	81823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,904.7	791.5	1,113.2	41.6
6	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх	770,400.0	670,812.3	99,587.7	87.1
7	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	20,641.3	20,641.3	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд 2 удаа зарласан боловч тендер харилцагч орж ирээгүй учир ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн. гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 572,176.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,443.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 5,366.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,366.0	2	5,366.0	100
Нийт дүн	2	5,366.0	2	5,366.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,868.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,368.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж 2,500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Цэцэрлэгийн эрхлэгч болон санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,368.1 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв

5.3 Зөвлөмж

1 Тус цэцэрлэг нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3. "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

2 Цалингийн сангаас 2,500.0 мянга төгрөгийг байгууллагын хөдөлмөрийн аврага ёс зүйн зөвлөлийн гишүүдэд шагнал, урамшуулал олгосон, батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"⁸ 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Батлагдсан төсвийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 02 сар 25 өдөр

Дугаар 01/56-24010611-2025-2025/107/108-СТВ Дархан сум
-ТМЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,368,100.00 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан," гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж, мөнгөн урамшуулал давхардуулан олгох зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч В.Отгонхүү, нягтлан бодогч Д.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.БАТБОЛД

4725040146

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон	1	5,368.1			1	5,368.1	1					
Батлагдсан төсөв эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй	1	2,500.0					1	2,500.0				
Дүн	1	7,868.1			1	5,366.1	1	2,500.0				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт Тоо	Дүн	Албан шаардлага Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0					1	0